



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/301

Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн
комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн 298 дугаар тушаал, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 298 дугаар тушаалаар батлагдсан журам, комиссын чиг үүргийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх ажлын албаны үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг комисс (Л.Лхамсүрэн)-т, Эрүүл мэндийн газар (Ч.Дэмчигсүрэн)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/204 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТСАЙХАН



Аймгийн Засаг даргын 2020 оны

d/zahiramj.doc

811290201

Аймгийн Засаг даргын 2020 оны
... дугаар сарын ... ны өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн

- Комиссын дарга - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Комиссын гишүүд: - Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн
хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: - Эрүүл мэндийн газрын хууль эрх зүй, эрүүл мэндийн
байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтний
ёс зүй хариуцсан мэргэжилтэн